

Эрдэнэ Ресурс нь өрөмдлөгийн хөтөлбөрөөр Баян Хөндий алтны ордын залгаа хэд хэдэн талбай дахь алтны эрдэсжилтийг тэллээ

Хэвлэлийн Мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот
2020.17.11

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ” эсвэл “Компани”) нь Хөндий Алтны Дүүрэгт төлөвлөсөн 18,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийн эхний үе шатны 10,000 метр хөтөлбөрийн эцсийн үр дүнг тайлагнан, Баян Хөндий ордтой залгаа хэд хэдэн талбайд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилтийг тэлснийг мэдээлэхэд таатай байна.

Онцлох мэдээлэл¹:

- Баян Хөндий ордоос баруун зүгт 200 метр-т Баруун Страйкер талбайд шинээр өндөр агуулга бүхий алтны интервал огтолсон:
 - VKD-334: 4.5 г/т алтны агуулга бүхий 14 метр интервалд 36.9 г/т алтны агуулга бүхий 1 метр багтсан бөгөөд энэ нь 2.5 г/т алтны агуулга бүхий 28 метр интервалд багтаж байна.
 - VKD-338: 5.5 г/т алтны агуулга бүхий 9 метр интервалд 23.3 г/т алтны агуулга бүхий 1 метр багтсан бөгөөд энэ нь 1.8 г/т алтны агуулга бүхий 38 метр интервалд багтаж байна.
 - VKD-339: 13.1 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал багтаасан 1.2 г/т алтны агуулга бүхий 54 метрийн интервал огтолсон.
- Баруун Страйкер бүс өмнө зүгт болон гүндээ үргэлжилж байгааг тогтоолоо (VKD-266):
 - VKD-341: 17.0 г/т алтны агуулгатай 1 метрийн интервал багтаасан 4.7 г/т алтны агуулга бүхий 4 метрийн интервал огтолсон.
- Ордын өмнө ба зүүн зүгт Өмнөд Страйкер талбайд газрын гадаргад ойр, өндөр агуулгыг тэллээ:
 - VKD-315: 37 метрийн гүнээс эхлэн 14.0 г/т алтны агуулга бүхий 1 метр багтаасан 5.0 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон.
 - VKD-316: 13 метрийн гүнээс эхлэн 21.7 г/т алтны агуулга бүхий 1 метр багтаасан 4.7 г/т алтны агуулга бүхий 5 метрийн интервал огтолсон.
- Зүүн Өмнөд Мидфийлд талбайн 200 метр структурын дагуу алтны эрдэсжилт үргэлжилж байна:
 - VKD-319: 2.8 метрийн гүнээс эхлэн, 14.5 г/т болон 28.9 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 2.9 г/т алтны агуулга бүхий 18.2 метрийн интервал огтолсон.
 - VKD-322: 3 метрийн гүнээс эхлэн 23.5 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 5.2 г/т алтны агуулга бүхий 7 метрийн интервал огтолсон.

Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч ба гүйцэтгэх захирал Петер Акерли: “Сүүлд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр ордын хязгаараас гадна хэд хэдэн бүсэд алтны эрдэсжсэн бүсийг тэлж, Баян Хөндий Алтны Төсөл, тэр дундаа Баруун Страйкер талбайд нөөцийг тэлэх боломжтойг харууллаа. Өмнө танилцуулсан 2020 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн болон одоогийн өндөр агуулга бүхий нөөцтэй залгаа оршиж байгаа Зүүн

¹ Энэхүү хэвлэлийн мэдээний үр дүнгүүд нь ОГТЛОЛЫН зузааныг танилцуулсан.

Өмнөд Мидфийлд, Хойд Мидфийлд, Өмнөд Страйкер талбайд өндөр агуулга бүхий бүсүүд илрүүлж, нийт алтны нөөцийг нэмэгдүүлэх боломжтойг харууллаа.”

“Хөндлөнгийн зөвлөх байгууллага өнөөгийн алтны үнэ, мэдээлсэн үр дүнгүүдэд тулгуурлан шинэчилсэн нөөцийн тооцоолол боловсруулах, нөөцийн захын агуулгыг тооцоолох зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ. Бид 2021 оны эхний хагаст Баян Хөндийн шинэчилсэн нөөцийг танилцуулахаар төлөвлөж байна.”

“Хайгуул судалгааны ажил хязгаарлагдмал хийгдсэн Дүүрэгт шинэ орд нээх, нөөцийг тэлэх боломжийг илэрхийлсэн үр дүнгүүд гарсанд баяртай байна. Хар Морь болон бусад хайгуулын эхний үе шатанд буй талбайд өрөмдлөгийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Одоогоор гүйцэтгэж буй хоёрдугаар үе шатны 8,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг энэ оны сүүлээр дуусгахаар төлөвлөсөн.”

Хүснэгт 1. Баян Хөндийн 3-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн

Талбай	Цооног	(м)-ээс	(м) хүртэл	Интервал (м) ⁽¹⁾	г/т Алт
Страйкер	BKD-315	37	40	3	4.95
	үүнд	37	38	1	14.04
	BKD-316	13	18	5	4.73
	үүнд	15	16	1	21.71
Зүүн Өмнөд Мидфийлд	BKD-319	2.8	21	18.2	2.87
	үүнд	4	5	1	14.49
	мөн	5	6	1	28.93
	BKD-322	3	10	7	5.19
	үүнд	5	6	1	23.47
	ба	14	18	4	1.06
	BKD-323	20	36	16	1.32
	үүнд	30	36	6	2.88
Баруун Страйкер	BKD-344	41	48	7	1.78
	BKD-328	93	94	1	2.61
	ба	149	159	10	4.00
	үүнд	151	155	4	9.44
	үүнд	152	153	1	25.13
	ба	218	225	7	1.55
	BKD-331	106	138.2	32.2	1.19
	үүнд	126	137	11	2.88
	үүнд	126	127	1	16.88
	BKD-334	122	150	28	2.46
	үүнд	125	139	14	4.49
	үүнд	125	126	1	36.93
	BKD-335	143	179	36	1.05
	үүнд	165	177	12	1.76
	BKD-336	99	119	20	0.37
	BKD-337	96	117	21	1.56
	ба	188	202	14	1.17
	BKD-338	108	146	38	1.75
	үүнд	124	133	9	5.49
	үүнд	124	125	1	23.29
	үүнд	129	130	1	14.32
	BKD-339	129	183	54	1.16
	үүнд	146	147	1	13.06
	BKD-340	59	62	3	0.65
ба	120	144	24	0.80	
үүнд	125	132	7	1.78	

Талбай	Цооног	(м)-ээс	(м) хүртэл	Интервал (м) ⁽¹⁾	г/т Алт
	BKD-341	21	22	1	4.31
	ба	243	247	4	4.71
	Түүнд	244	245	1	16.96
	BKD-342	94	107	13	0.51
	ба	129	132	3	1.46
	ба	189	204	15	1.48

¹ Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Өрөмдлөгийн цооногууд нь баруун хойд унал, баруун өмнөд баруун алтны судлыг хэвийн огтлоход чиглэсэн байсан тул мэдээлсэн зузаан нь бодит зузаантай дүйцэхүйц байна.

Баян Хөндий ордын тэлэлт – Өрөмдлөгийн онцлох үр дүн ба төлөвлөгөө

(План зураглал, хөндлөн зүсэлт ба дээжийн зурагтай хавсралтаас танилцана уу)

Баян Хөндийн алтны нөөцийг Тетра Тек 2019 онд гүйцэтгэсэн бөгөөд 3.16 г/т алтны агуулга бүхий 521,000 унц баттай & бодитой нөөц, 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц агуулагдаж байна. Баттай ба бодит нөөцөд төлөвлөсөн ил уурхайн 3.7 г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөц тооцоологдсон (хэвлэлийн мэдээтэй энд дарж танилцана уу). Дээрх нөөцийг 0.55 г/т захын агуулга ба алтны үнийг \$1,350 ам.доллар/унцаар тооцож боловсруулсан.

Энд танилцуулсан сорьцын шинжилгээний хүснэгт, төлөвлөгөө болон хөндлөн зүсэлтүүд нь алтны эрдэсжсэн бүсүүдийн захын агуулгыг 0.4 г/т-оор тооцоолсон. Өсөн нэмэгдэж буй алтны үнэ нь захын агуулгын тооцоололд эерэгээр нөлөөлөх бөгөөд өрөмдлөгийн үр дүнгүүд нь геологийн болон үйлдвэрлэлийн нөөцийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Энэхүү хэвлэлийн мэдээнд тусгагдсан өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн нь нийт 6,370 тууш метр 37 цооногийг хамарна. Эдгээрийн найман цооног нь Зүүн Өмнөд Мидфийлд бүсэд, долоон цооног нь төлөвлөсөн ордын хязгаар, Страйкер бүстэй өмнө зүгт залгаа талбайд, 14 цооног нь Баруун Страйкер, дөрвөн цооног нь Страйкер болон Мидфийлд талбайн цооногийн үргэлжлэл, 1 цооног нь Зүүн Хойд Баян Хөндий талбайд, гурван нарийвчилсан судалгааны цооногууд байна. 3-р улиралд танилцуулсан Баян Хөндийн өрөмдлөгийн хөтөлбөрийн 12 цооногийн үр дүнд (2020 оны 10 сарын 1-ний хэвлэлийн мэдээтэй энд дарж танилцана уу) 8,435 тууш метр бүхий 49 цооног багтсан.

3-р улирлын тэлэлтийн өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох мэдээлэл

Баруун болон Өмнөд Страйкер

Баруун ба Өмнөд Страйкер талбай нь Страйкер талбайн баруун хэсгээс өмнө зүгт өрөмдсөн цооног хүртэл нийт 350 метр (Өмнөөс хойш) 400 метр (Зүүнээс баруун) талбайг хамран оршдог. 2020 оны өрөмдлөгийн хөтөлбөр нь өндөр агуулга бүхий Баруун Страйкер бүсийн орчимд болон төлөвлөсөн ордын хязгаараас өмнө зүгт газрын дөт гүнд алтны эрдэсжсэн бүсийг тэлэх боломжтой эсэхийг шалгах зорилготой байв. Баруун Страйкер бүсийн өрөмдлөгөөр өндөр агуулга бүхий бүсүүдийг тэлэх, цооног хоорондын зайг ойртуулснаар бүсүүдийн үргэлжлэлийг шалгасан. Энэхүү зорилт амжилттай хэрэгжин, төлөвлөсөн ордын хязгаараас өмнө зүгт газрын дөт гүнд өндөр агуулга бүхий талбайг тэлж, Баруун Страйкер бүс дэх цооног хоорондын зайг ойртуулснаар урд зүг дэх дөт гүний бага агуулга бүхий бүсээс хойш чиглэлтэй өндөр агуулга бүхий бүсүүдийг тодорхойлж, өндөр агуулга бүхий эрдэсжилтийн хязгаарыг тэлсэн.

Баян Хөндий ордын өмнөд хязгаараас эхлэн, төлөвлөсөн ордын хязгаараас гадна газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий талбай үргэлжилж буйг шалгах аар өрөмдсөн. Бага агуулга бүхий материал агуулж буй өргөн бүсүүдэд хийсэн өрөмдлөгөөр гурван цооногт газрын гадаргаас 30 метрт 14-54 г/т алтны агуулга бүхий (BKD-312, 315, 316) 1 метрийн интервалууд огтолсон. Энэхүү цооногууд нь 2020 оны 7 сарын 15-ны хэвлэлийн мэдээнд танилцуулсан (цооногийн амсраас 0.9 метрт) 353 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 29 г/т алтны агуулгатай 15 метрийн интервал бүхий BKD-292 цооногоос хойд зүгт 65 метр-т байрлаж байна.

Баруун Страйкер бүсэд урьд нь илрүүлсэн өндөр агуулга бүхий цөм нь Баян Хөндий ордоос баруун зүгт 200 метрт оршдог (2019 оны өрөмдлөгөөр BKD-265 цооногт 136 метрийн босоо гүнд 40 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон). Энэхүү өндөр агуулга бүхий бүс нь төлөвлөсөн ордын нөөцийн (нэг унц алтыг \$1,350 ам.доллараар тооцоолсон) ойролцоо оршдог. Дээрх нөөцийн хязгаараас хойд зүгт орших шинэ, өндөр агуулга бүхий талбайн цооног хоорондын зай нь ойролцоогоор 40 метр бөгөөд энэхүү талбайн хэд хэдэн цооногт (BKD-334, 335, 337, 338, 339) 13.6-36.9 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 1 г/т алтны агуулга бүхий 20-50 метрийн интервалуудыг огтолсон. Эдгээр цооногт хэд хэдэн 0.4 г/т-с өндөр алтны агуулга бүхий эрдэсжсэн бүс агуулагдаж байна (Хүснэгт 2-той танилцана уу).

Баруун Страйкерийг өмнө зүгт үргэлжлүүлэн өрөмдсөнөөр, өмнө нь танилцуулсан 28 метрээс 1.1 г/т алтны агуулга бүхий 16 метрийн интервал (BKD-265) огтолсон талбайд газрын гадаргаас 20 метрийн гүнд 4.3 г/т алтны агуулга (BKD-341 цооногт 1 метр) хүртэл интервалуудыг огтолсон. Хэдийгээр алтны агуулга бага боловч газрын дөт гүн дэх бүс нь төлөвлөсөн ордын хязгаарыг Баруун Страйкер талбай руу тэлэх боломжтой.

Түүнээс гадна, Баруун Страйкер талбайн урд зүгт газрын гүн дэх бүсийг огтоллоо. BKD-241 цооног нь 243 метрт 4.7 г/т алтны агуулга бүхий 4 метрийн интервал огтолсон нь 17.0 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал агуулж байна. Энэ цооног нь 2019 оны сүүлээр илрүүлсэн 51.9 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал огтолсон (BKD-266) цооноогоос үргэлжлэн хазайж (35 метрт), өмнө зүгтээ нээлттэй байна. Энэхүү 2 интервал нь өргөн (1 метрээс өргөн) кварцын судалтай холбоотой.

Зүүн Өмнөд Мидфийлд

Энэ оны эхээр танилцуулсан газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий Зүүн Өмнөд Мидфийлд нээлтээр энэхүү талбайг баруун хойш чиглэлтэй кварц-адулярын бүлэг судлууд, хойш-урагш чиглэлтэй хэмээн таамаглаж буй тэжээгч структурын огтлол хэмээн тайлсан.

BKD-288 цооногт 11.5 метрийн гүнд 581.6 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 125.9 г/т алтны агуулга бүхий 5.5 метрийн интервал огтолсон. BKD-288 цооноогоос хойд зүгт 40 метрт орших BKD-274 цооногт 14.9 метрийн гүнд 25.6 г/т алтны агуулга бүхий 25 метрийн интервал огтолсон.

Зүүн Өмнөд Мидфийлд талбайд 150 метрийн суналын дагуу 8 цооногт өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэсэн. Хөтөлбөрөөр зарим тохиолдолд бага алтны агуулгатай боловч талбайн суналын дагуу кварц-гематит брекчтэй холбоотой алтны эрдэжилт байгааг баталгаажуулсан. Урьд нь өндөр агуулга бүхий интервал огтолсон цооногтой зэрэгцээ өмнө зүгт хийсэн өрөмдлөгөөр хамгийн өндөр агуулгууд илэрсэн: BKD-319 цооногт 2.8 метрт 2.9 г/т алтны агуулга бүхий 18.2 метрийн интервал огтолсон нь 14.5 г/т болон 28.9 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулж байна. BKD-322 цооногт 3 метрээс эхлэн 5.2 г/т алтны агуулга бүхий 7 метрийн интервал огтолсон нь 23.5 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервалыг агуулж байна.

Өнөөгийн нөөцийн тооцоололд хаягдал эсвэл бага агуулга бүхий овоолгын материалд ангилсан энэхүү бүс нь олборлолтын эхэн үед эдийн засгийн эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтойг баталлаа.

Өнөөгийн өрөмдлөгийн хөтөлбөр

Хар Морь хэтийн төлөв бүхий талбай нь 1.5км*2км талбайг хамран оршдог. 2020 оны 10 сарын 26-нд танилцуулсан хэвлэлийн мэдээгээр хоорондоо 1,250 метрийн зайтай хоёр цооногт (AAD-41 ба AAD-48) өндөр агуулга бүхий алтны эрдэсжсэн интервалууд огтлогдсон.

Нийт 11 цооногт алтны аномаль эрдэжилт болон/эсвэл индикатор элементүүд (As, Mo, Sb)-ийн аномаль илэрсэн бөгөөд энэхүү эрдэжилт нь зүүн хойд- баруун өмнөд төв структур, түүний салбаруудыг дагасан нам соронзон орон ба хөрсөн дэх алтны гажилтуудын давхцалуудтай холбоотой болохыг баталгаажуулсан. Хар Морь талбайд 1,850 метр 8 цооногийн өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлсэн. Ирэх долоо хоногуудад Хөндий Дүүрэгт нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхээр хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд:

2020 оны хайгуулын улиралд, компани нь аюулгүй, үр дүнтэй хайгуулын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд COVID-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Компани COVID-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдээ үргэлжлүүлэн, хээрийн ажлын хүрээнд гараа тогтмол угаах, байнгын ариутгал цэвэрлэгээ хийх зэргээр агааржуулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг авч, ажилтнуудаа халдвараас сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Өдөр тутам сэрэмжлүүлэг, зөвлөмжийг өгч, танилцуулга хийн, зочин хүлээн авах журмыг шинэчилж, биеийн халууныг шалгах ажлыг тогтмолжууллаа. Шаардлагатай нөхцөлд ашиглах зорилгоор тусгаарлах байр, хувийн хамгаалалтын хэрэгслүүдийг бэлтгэсэн.

Нэгдүгээр сараас эхлэн Монгол Улсын Засгийн газар олон улсад зорчих иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах, бүх шатны хичээл сургалтын үйл ажиллагааг хязгаарлах, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох зэргээр иргэдээ вирусээс хамгаалах арга хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлж байсан. 2020 оны 11 сарын 12-ноос вирусний халдвар голомтлон тархсанаас үүдэн Монгол Улсын Засгийн газар 2020 оны 12 сарын 1 хүртэл дотоодын хөл хөдөлгөөнийг хориод байна. Компанийн Улаанбаатар хот дахь оффис түр хугацаанд хаагдан, захиргааны ажилтнууд зайнаас ажиллаж байна. Хайгуулын хөтөлбөр үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд хоол хүнс, шатахуун зэрэг шаардлагатай хангамжууд тасралтгүй хүргэгдэж байгаа болно.

COVID-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэхэд бие сэтгэлээ зориулж буй эрүүл мэндийн ажилтан албан хаагчид, цагдаа, тусгай үүргийн албан хаагч нартаа компанийн зүгээс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хөндий Алтны Дүүргийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц² (“Measured and Indicated Resources”)³, 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтаж байна. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7 сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны

² Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд SEDAR-т байршуулсан Тетра Текийн боловсруулсан NI 43-101 техникийн тайлангаас танилцана уу.

³ Баттай ба бодит геологийн нөөц: 3.77 г/т алтны агуулга бүхий 171,000 унц баттай нөөц, 2.93 г/т алтны агуулга бүхий 349,700 унц бодит нөөц

дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор алтыг ялган авахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2022 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com -оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэгтул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс ("SGS") лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмт спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screenmetallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс ("SGS") лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Өрөмдлөгийн цооногууд нь баруун хойд унал, баруун өмнөд баруун алтны судлын хэвийн огтлоход чиглэсэн байсан тул мэдээлсэн зузаан нь бодит зузаантай маш ойрхон байна. Гэвч геологийн параметрууд нь судлын чиглэлд нөлөөлөх боломжтой. Үүнийг баталгаажуулахын тул нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Дээд зүсэлт хийгдээгүй боловч илүү тодорхой болгохоор 10 г/т алтны агуулгаас дээш интервалуудыг дангаар нь тайлагнадаг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон

таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>

BAYAN KHUNDII

Reserve and Resource Expansion Zones

Bayan Khundii Proposed Economic Pit:
409,000 ounces of Gold
Reserves @ 3.7g/t

Reserves


1. Striker
2. Midfield
3. Midfield North

Expansion Areas

- A. Striker West
- B. Striker South
- C. Midfield SE
- D. Northeast

Pit Constrained Resource:

M&I 521,000 ounces @ 3.16g/t gold
Inferred resource of 103,000 ounces @ 3.68 g/t gold outside of pit



- Q3 2020 Collar (New)
- Q3 2020 Collar (Released)
- Q2 2020 Collar
- Pre 2020 Collar
- Low Grade Shell (0.4-2 g/t Au)
- High Grade Shell (>2 g/t Au)
- Economic Pit Shell
- Resource Constrained Pit Shell




200m

STRIKER WEST EXTENSION

Q3 2020 Drill Highlights


Section 'A' Looking North

Bayan Khundii Economic Pit Shell



STRIKER WEST EXTENSION

Section 'B' Looking East



Midfield Southeast Expansion Area C 2020 Drill Results Magnetics - Vertical Derivative

Gold bearing
Quartz-Hematite Breccia
(BKD-288)



Legend

Quartz-Hematite Breccia Surface Exposure

Q3 2020 Collar (New)


Q3 2020 Collar (Released)


Q2 2020 Collar

Pre 2020 Collar


Q2 2020 Results

Q3 2020 Results







BKD-292 @ 5.54m
Quartz-Adularia vein Abundant
Visible Gold
5.0 - 6.0m returned 353 g/t Au



BKD-297 @ 5.54m
Quartz-Adularia vein
(colloform-crustiform textures)
4.0 - 5.0m returned 38.78 g/t Au



BKD-328 @ 152 m
Quartz-Adularia-Hematite vein with
multiple sightings of Visible Gold
152.0 - 153.0 m returned 25.13 g/t Au



BKD-341 @ 244.6m
1.7m wide Quartz vein with Abundant
Visible Gold
244.0 - 245.0 m returned 16.96 g/t Au

Хүснэгт 2. 0.4 г/т алтны агуулгаас дээш үр дүнг тайлагнасан

Талбай	Цооног	(м)-ээс	(м) хүртэл	Интервал (м) ⁽¹⁾	г/т Алт
Баруун Өмнөд Страйкер	BKD-312	2	6	4	0.75
	ба	13	16	3	21.43
	үүнд	14	15	1	53.83
	ба	31	36	5	1.06
	ба	114	127	13	1.01
Баруун Өмнөд Страйкер	BKD-313	132	133	1	3.62
Баруун Өмнөд Страйкер	BKD-314	15	17	2	0.42
Страйкер	BKD-315	21	26	5	0.88
	ба	37	40	3	4.95
	үүнд	37	38	1	14.04
	ба	119	120	1	0.81
Страйкер	BKD-316	0	2	2	0.40
	ба	13	18	5	4.73
	үүнд	15	16	1	21.71
	ба	24	25	1	0.66
	ба	42	48	6	0.51
	ба	78	82	4	0.41
Страйкер	ба	208	210	2	0.45
	BKD-317	10	15	5	0.74
	ба	36	38	2	0.49
	ба	49	51	2	1.42
	ба	182	187	5	0.54
Страйкер	BKD-318	15	17	2	1.38
	ба	48	50	2	2.47
	ба	71	82	11	0.54
	BKD-319	2.8	21	18.2	2.87
Зүүн Өмнөд Мидфийлд	үүнд	4	5	1	14.49
	үүнд	5	6	1	28.93
	ба	41	43	2	1.61
	BKD-320	0	1	1	3.26
Зүүн Өмнөд Мидфийлд	ба	4	8	4	1.01
	ба	12	13	1	0.63
	BKD-321	11.5	13	1.5	0.76
Зүүн Өмнөд Мидфийлд	ба	24	32	8	0.70
	ба	37	40	3	0.56
	ба	46	62	16	0.79
	ба	70	75	5	0.62
	BKD-322	3	10	7	5.19

Талбай	Цооног	(м)-ээс	(м) хүртэл	Интервал (м) ⁽¹⁾	г/т Алт
	үүнд	5	6	1	23.47
	ба	14	18	4	1.06
	ба	34	40	6	0.55
	ба	44	45	1	2.45
	ба	47	48	1	1.07
Зүүн Өмнөд Мидфийлд	BKD-323	20	36	16	1.32
	үүнд	30	36	6	2.88
Зүүн Өмнөд Мидфийлд	BKD-324	46	47	1	0.50
Зүүн Хойд Бүс	BKD-325	120	124	4	0.50
Нарийвчилсан судалгааны цооног	BKD-326	Ач холбогдол бүхий эрдэсжилт илрээгүй			
Нарийвчилсан судалгааны цооног	BKD-327	Ач холбогдол бүхий эрдэсжилт илрээгүй			
Баруун Страйкер	BKD-328	93	94	1	2.61
	ба	149	159	10	4.00
	үүнд	151	155	4	9.44
	үүнд	152	153	1	25.13
	ба	218	225	7	1.55
	ба	290	294	4	0.48
	ба	297	299.3	2.3	0.51
Баруун Страйкер	BKD-329	6	8	2	1.01
Нарийвчилсан судалгааны цооног	BKD-330	Ач холбогдол бүхий эрдэсжилт илрээгүй			
Баруун Страйкер	BKD-331	106	138.23	32.23	1.19
	үүнд	126	137	11	2.88
	үүнд	126	127	1	16.88
Баруун Страйкер	BKD-332	196	214	18	0.48
	ба	222	224	2	0.60
Баруун Страйкер	BKD-333	132	141	9	0.71
Баруун Страйкер	BKD-334	122	150	28	2.46
	үүнд	125	139	14	4.49
	үүнд	125	126	1	36.93
	ба	201	226	25	0.40
Баруун Страйкер	BKD-335	114	118	4	0.61
	ба	132	134	2	0.64
	ба	143	179	36	1.05
	үүнд	165	177	12	1.76
Баруун Страйкер	BKD-336	99	119	20	0.37
	ба	168	172	4	0.57
Баруун Страйкер	BKD-337	96	117	21	1.56
	ба	134	139	5	0.68
	ба	143	145	2	0.45
	ба	188	202	14	1.17

Талбай	Цооног	(м)-ээс	(м) хүртэл	Интервал (м) ⁽¹⁾	г/т Алт
Баруун Страйкер	BKD-338	108	146	38	1.75
	үүнд	124	133	9	5.49
	үүнд	124	125	1	23.29
	үүнд	129	130	1	14.32
	ба	154	178	24	0.42
	ба	194	197	3	0.95
ЕОН	ба	202	208	6	0.62
	ба	264	272.5	8.5	0.68
	ба	264	272.5	8.5	0.68
Баруун Страйкер	BKD-339	70	98	28	0.49
	ба	129	183	54	1.16
	үүнд	146	147	1	13.06
Баруун Страйкер	BKD-340	59	62	3	0.65
	ба	120	144	24	0.80
	үүнд	125	132	7	1.78
Баруун Страйкер	BKD-341	21	22	1	4.31
	ба	243	247	4	4.71
	үүнд	244	245	1	16.96
Баруун Страйкер	BKD-342	94	107	13	0.51
	ба	129	132	3	1.46
	ба	189	204	15	1.48
Мидфийлд	BKD-343	148.73	164	15.27	0.79
Зүүн Өмнөд Мидфийлд	BKD-344	0	1	1	1.49
	ба	4	8	4	0.55
	ба	14	16	2	0.55
	ба	26	30	4	0.55
	ба	41	48	7	1.78
Зүүн Өмнөд Мидфийлд	BKD-345	7	11	4	0.69
	ба	22	23	1	1.42
Страйкер (Тэлэлтийн цооног) 100м-172м	BKD-80X	101	104	3	0.53
	ба	127	128	1	0.86
Мидфийлд (Тэлэлтийн цооног) 145.9м-176м	BKD-112X	Ач холбогдол бүхий эрдэсжилт илрээгүй			
Мидфийлд (Тэлэлтийн цооног) 154.5м-193.5м	BKD-155X	Ач холбогдол бүхий эрдэсжилт илрээгүй			
Страйкер (Тэлэлтийн цооног) 150М-40м	BKD-227X	206	222	16	0.54

¹ Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Өрөмдлөгийн цооногууд нь баруун хойд унал, баруун өмнөд баруун алтны судлын хэвийн огтлоход чиглэсэн байсан тул мэдээлсэн зузаан нь бодит зузаантай маш ойрхон байна.